

## СҮХБААТАР АЙМГИЙН АРХИВЫН ТАСАГ

Сүхбаатар аймгийн архив 1957 онд байгуулагдсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн Архивын тасаг.



Зохион байгуулалтын нэгжийн нэр	Албан тушаал	Орон тоо
Архивын тасаг	Тасгийн дарга	1
	Сан хөмрөгийн эрхлэгч	1
	Архивч	1
	Гэрээт архивч	5
Нийт		8


### Сан хөмрөг:

Хөмрөг үүсгэгчийн нийт тоо 124. Үүнээс: Төрийн байгууллага 113, Төрийн өмч оролцсон аж ахуйн нэгж 2, Улс төрийн нам 1, Олон нийтийн байгууллага 3, Төрийн бус бусад байгууллага 4, Хувийн хэвшлийн аж ахуй нэгж 1. Хөмрөгийн нийт тоо 124. Хадгалагдаж буй баримтын тоо хэмжээ 32129 хадгаламжийн нэгж.


Баримтын төрөл	Он цаг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт дүн	Тайлбар
Цаасан суурьтай баримт	1942-2006	Хуудсаар	57792078	-	
Кино хальс	1983	Метрээр	8м 35см		
Гэрэл зураг		Ширхэгээр	30		
Бусад			31		

Сүхбаатар аймгийн архивт БНМАУ-ын анхны Ерөнхийлөгч П.Очирбатын аймагт айлчилсан баримт бичиг, Алтан овооны их тахилгын материал, Аймгийн бэлэг тэмдэг далбааг байрлуулах үйлдэх дүрслэх журам, Хүндэт иргэн өргөмжлөл олгох тухай, Аймгийн 60 жилийн


материал, Төр нийгмийн зүтгэлтэн М. Дугаржавын амьдрал уран бүтээл, Төмөртийн овооны цайрын ордыг ашиглах үйлдвэрийн нээлтийн ажиллагаатай холбогдсон баримт, Их Монгол улс байгуулагдсаны 800-н жилийн ойн баримт, Д. Сүхбаатар мэндэлсний 100-н жилийн ойд бэлтгэж, тэмдэглэн өнгөрүүлсэн материал, “Сүхбаатар аймагт хөрөнгө оруулах боломж” чуулга уулзалтын материал зэрэг онцлог баримтууд хадгалагдаж байна.



Дорнод аймгаас 10 сум, Хэнтий аймгаас 4 сум тус тус шилжүүлэн 14 сумтай шинэ аймгийн нэрийг Жавхалант шарга дээр төвлөрүүлэн байгуулсан тухай БНМАУ-ын Улсын Бага Хурал Тэргүүлэгчдийн 1941 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр хурлын тогтоол.



Д.Сүхбаатарын дурсгалыг мөнхжүүлэх тухай Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1943 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоол



Жавхалант шарга аймгийн яам эсгий гэрт байрлаж байжээ. /1942-1943/



Сүхбаатар аймгийн засаг захиргааны зураг. 1965 он

**Хаяг:**

Сүхбаатар аймаг, Баруун-Урт хот, 7 дугаар баг, Сүхбаатарын талбай  
Цахим шуудан: [sukhbaatar@archives.gov.mn](mailto:sukhbaatar@archives.gov.mn)

**Харилцах утасны дугаар:**

Тасгийн дарга: 93019319  
Сан хөмрөгийн эрхлэгч: 98898840